



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 16 өдөр


Дугаар А/188

Улаанбаатар хот

Голомтод халдваргүйжүүлэлт
хийх түр заавар

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 62 дугаар тогтоолын 3 дахь заалт, Улсын онцгой комиссын хурлын 07 дугаар хурлын тэмдэглэлийн 2.1 дүгээр заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалын 8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед халдваргүйжүүлэлт хийх тухай түр зааврыг хавсралтаар баталсугай.
2. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх, бэлэн байдлыг ханган, болзошгүй эрсдлээс хамгаалж, уг тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Н.Цогбадрах)-д даалгасугай.
3. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг тухай бүр зохион байгуулан ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга (Т.Энхзаяа)-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д даалгасугай.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ

• 141200663

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 05 сарын 16 өдрийн 11 дугаар
тушаалын хавсралт 1188

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ГОЛОМТОД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР

Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтаас сэргийлэх зорилгоор эцсийн халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаанд энэхүү түр зааврыг баримтална.

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1. Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар голомтын халдваргүйжүүлэлт хийх багийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана;
- 1.2. Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг Нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ) аймаг, сумын түвшинд харьяа Зоонозын өвчин судлалын төв (ЗӨСТ), тус төв байхгүй орон нутагт нэгдсэн эмнэлэг хариуцан хийнэ;
- 1.3. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед тусгай мэргэжлийн төвүүд 5 ба түүнээс дээш, Нийслэлийн түвшинд 4, аймгийн түвшинд 3, сумын түвшинд 2 голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх багийг томилж, бэлэн байдлыг хангасан байна;
- 1.4. Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлт гарч, ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн хүчин чадал хүрэлцэхгүй болсныг мэдэгдсэн тохиолдолд тусгай мэргэжлийн төвүүд, аймаг, Нийслэлийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвөөс томилогдсон нэмэлт халдваргүйжүүлэлтийн багийг дайчлан ажиллуулна;
- 1.5. Томилсон багийн бүрэлдэхүүнийг тухайн эрүүл мэндийн байгууллага ариутгал, халдваргүйжүүлэлтийн чиглэлээр сургаж, дадлагажуулсан байна;
- 1.6. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй, магадлалтай болон батлагдсан тохиолдол эмнэлэгт бүртгэгдсэн үед эцсийн халдваргүйжүүлэлтийг тухайн эмнэлгийн томилж, бэлтгэгдсэн халдваргүйжүүлэлтийн баг хийж гүйцэтгэнэ;
- 1.7. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг өвчтний гэр, ажлын байр, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон тусгаарласан өрөө, өвчтөн нас барсан газар, зөөвөрлөсөн тээврийн хэрэгсэлд хийж гүйцэтгэнэ;
- 1.8. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлын онош батлагдаагүй байгаа нөхцөлд ажиглалтын байранд голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхгүй;

- 1.9. Халдваргүйжүүлэх бодис нь Улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаажилттай, хадгалах хугацаа дуусаагүй, хаяг шошго, сав баглаа бүрэн бүтэн, хэрэглэх аргачлал тодорхой байх бөгөөд үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулан хэрэглэнэ;
- 1.10. Давтан хэрэглэх эмнэлгийн багаж хэрэгслийг цэвэрлэх халдваргүйжүүлэх, ариутгахдаа эрүүл мэндийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаал (Одоо мөрдөгдөж байгаа 2019 оны ЭМС-ын 537 дугаар тушаалын 2 дугаар хавсралт)-ыг мөрдөнө;
- 1.11. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийхдээ томилогдсон баг нь эрүүл мэндийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас (Одоо мөрдөгдөж байгаа Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/161 дүгээр тушаал) баталсан халдвараас сэргийлэх, биоаюулгүй ажиллагааны зааврыг мөрдөн ажиллана;
- 1.12. Хүснэгтэд заасан халдваргүйжүүлэлтийн бодисоос сонгож, үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

ХОЁР. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ГОЛОМТЫН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН БАГИЙН ҮҮРЭГ

- 2.1. Голомтод халдваргүйжүүлэлт хийх баг нь тархвар судлагч эмчийн хяналтад дор ажиллана;
- 2.2. Халдваргүйжүүлэлтийн багийн гишүүд нэг удаагийн иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслийг халдваргүй бүс буюу ногоон бүсэд өмсөнө;
- 2.3. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх эмнэлгийн ажилтан дараах нэг удаагийн хамгаалах хэрэгслийг халдвараас сэргийлэх зааврын дагуу өмсөнө;
 - Нэг удаагийн малгай
 - Шүүлтүүртэй амны хаалт
 - Нүдний шил
 - Нүүрний хаалт
 - Бээлий (давхар резинен бээлий)
 - Ханцуйвч
 - Комбинзон
 - Нэг удаагийн халад (шаардлагатай тохиолдолд давхар өмсөх)
 - Хормогч (шаардлагатай тохиолдолд)
 - Ус нэвтэрдэггүй түрийтэй гутал
- 2.4. Халдваргүйжүүлэлтийн бодисыг цэвэр саванд зааврын дагуу найруулна. Уусмалын үлдэгдэл дээр шинээр уусмал нэмж найруулахыг хориглоно;

- 2.5. Халдваргүйжүүлэлт хийхээс өмнө байрны цонх, хаалгыг хаана;
- 2.6. Эцсийн халдваргүйжүүлэлт хийхэд байрны гадна тал хаалганаас эхэлж, гадна талаас дотогш болон дээрээс доош чиглэлээр халдваргүйжүүлэлт хийнэ;
- 2.7. Өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлт хийхдээ гар хүрэх газруудад аль болох арчиж халдваргүйжүүлнэ. Тааз, хананы дээд хэсэг, их талбайг хамарсан халдваргүйжүүлэлт хийх үед автомакс болон шүршигч ашиглан сайтар шүршинэ;
- 2.8. Тоног, төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд зүйлсийн гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий алчуураар арчина;
- 2.9. Хоол хүнсний сав, аяга тавга зэрэг хэрэгслийг зориулалтын угаагч шингэн бүхий халуун усаар угаана. Халдваргүйжүүлэх бодис хэрэглэх шаардлагагүй;
- 2.10. Халдваргүйжүүлэлт хийж дууссаны дараа хэрэглэсэн хамгаалах хувцас хэрэгслийг шар бүсэд зааврын дагуу тайлна;
- 2.11. Халдваргүйжүүлэлт хийснээс хойш 1-2 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийж, өрөөг агааржуулна;
- 2.12. Хамгаалах хувцас хэрэгсэл болон халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны үед гарсан халдвартай хог хаягдал цуглуулах шар уут бүхий хог хаягдлыг зориулалтын тагтай саванд хийж, савны гадна талыг халдваргүйжүүлэлтийн уусмалаар шүршиж, зөөвөрлөн хог хаягдлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас (Одоо мөрдөгдөж байгаа Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 дугаар тушаал)-аар баталсан "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар"-ын дагуу устгана;
- 2.13. Ойрын хавьтал, өвчтөн, цогцос зөөвөрлөсөн (нүүлгэн шилжүүлсэн) тээврийн хэрэгсэлд тухай бүр эцсийн халдваргүйжүүлэлтийг заавал хийнэ.

ГУРАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ГОЛОМТОД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

Хүснэгт 1

№	Халдваргүйжүүлэх зүйлсийн нэр	Халдваргүйжүүлэх аргачлал	Халдваргүйжүүлэх бодисын нэр (дараах бодисуудаас сонгож хэрэглэх)	Халдваргүйж үүлэх бодисын үйлчлэх хугацаа	Зарцуулах хэмжээ
1	Өвчтөний – Цэр идээ – Шээс – Өтгөн – Цус – Ялгадасны сав – Бусад	– Холих – Дүүргэж хийх	– 0.1%-ийн жавелион – 0.04 %-ийн ДП-2Т – Хлорклийн 0.05%	1 цаг	161 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, вирус риккетсүүдийн халдваргүйтгэл хийх хүснэгт, 3 дугаар заалт
2	Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнээр бохирлогдсон талбай, гадаргуу	- Шүрших	– 0.06%-ийн жавелион – 0.04 %-ийн ДП-2Т – Хлорклийн 0.05%	1 цаг	ЭМС-ын 537 дугаар тушаалын 6 дугаар хавсралт 3 дугаар заалтыг баримтлана.
3	Зөөлөн эдлэл /Цагаан хэрэглэл, хувцас гэх мэт/	- Дежкамер	Уур агаарын холимог (85 – 90°)	45 минут	ЭМС-ын 537 дугаар тушаалын 8 дугаар хавсралтыг баримтлана.
		- Автоклав	1.5 атм 126°	30 минут	
4	Орон байр, гэр, майхан тавилгын гадаргуу, өвчтөний өрөө, (хана, тааз туурга, хаалга, цонх, тавцан, шал, ажлын ширээ, ор, шүүгээ, бусад эд зүйлс)	- Дүрэх - Живүүлэх	- 0.06%-ийн жавелион - 0.04 %-ийн ДП-2Т	1 цаг	Халдваргүйжүүлэх уусмалд дүрэх, живүүлэх аргыг хэрэглэнэ.
		- Шүрших (Агаарт мананцар үүсгэхгүй) - Арчих	- 0.06%-ийн жавелион - 0.04% ДП-2Т - 0.03% клорклийн	1-2 цаг	

5.	Өрөө тасалгааны агаарыг халдваргүйжүүлэх	- Мананцартуулан шүрших	- 0.03%-ийн жавелион - Устөрөгчийн хэт исэл 3%	1 цаг	- 1 м2 талбайд 100 мл байхаар тооцож шүршинэ. - 1 м2 талбайд 40 мл байхаар тооцож шүршинэ
6.	Өвчтөний үлдэгдэлтэй сав, суулга, аяга, таваг	- Угаах	2%-ийн содын уусмал эсвэл зориулалтын угаагч шингэнээр угаах	30 минут	Угаах аргыг ашиглана
7.	Өвчтөн ба цогцос зөөвөрлөсөн тээврийн хэрэгсэл	- Шүрших - Арчих	- 3%-ийн устөрөгчийн хэт исэл - 0.06%-ийн жавелион - 0.04%-ийн ДП-2Т - 0.05%-ийн клорклийн	1 цаг	1м ² талбайд 500 мл халдваргүйжүүлэх бодис хэрэглэхээр тооцож шүршинэ. Халдваргүйжүүлэх уусмалыг найруулж арчина.
8.	Ил задгай нүхэн жорлон	-	-Гипохлорит кальц		1м ² талбайд 500 мл халдваргүйжүүлэх бодис хэрэглэхээр тооцож шүршинэ. Хлорын шохойн 20-40%-ийн сүүн уусмалыг бэлтгэнэ. Бэлтгэхдээ 2-4 кг хуурай хлорын шохойг хэмжин авч, бага зэргийн усыг жигд холимог болтол нь нэмж, сайтар хольж хутгаад, 10 л хүртэл ус нэмж, тасалгааны хэмд 24 цаг тавина. Үүссэн тунгалаг уусмалыг ашиглана.

---000---